



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Эрүүл мэндийн ажилтныг үзлэг, шинжилгээ,
эмчилгээнд хамруулах тухай

Вирүсын шалтгаант элэгний үрэвсэлт өвчин дэлхий дахинд хамгийн их тархсан өвчин бөгөөд улс орнуудын хувьд шийдвэрлэх тулгамдсан асуудал болж байна. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг Эрүүл мэндийн яам хариуцан боловсруулж байна.

Хепатитийн С вирүсын халдвар манай улсын хүн амын дунд 36.4 хувь¹, эрүүл мэндийн байгууллагад ажиллагсадын дунд 22 хувь² хүрсэн нь өндөр тархалттайд тооцогдож байна. Эрүүл мэндийн ажилтнуудын дийлэнх нь ажлын байран дээрээ тариур, иртэй багажинд хатгуулдаг ба жилд дунджаар 2.3 удаа хатгалтад өртдөг, түүнчлэн тэдний эрүүл мэндийн байгууллагад ажилласан жил нь хепатитийн С вирүсын халдварын эрсдэлт хүчин зүйл болж байгаа бөгөөд ажилласан жил нэгээр нэмэгдэхэд дээрх эрсдэл 10 хувиар нэмэгддэгийг судалгаагаар нотолжээ.

Нийт хүн амд чанартай тусламж, үйлчилгээг хүргэхийн тулд эрүүл мэндийн ажилтан хүн өөрөө эрүүл саруул биетэй, эрсдэл, аюулгүй, найдвартай орчинд ажиллах ёстой. Эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа нь халдварт өртөх эрсдэл дагуулдаг тул эхний ээлжинд эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулж, цаашид нийт хүн ам руу чиглэсэн “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр элэгний С вирүсын голомтыг 2020 он гэхэд устгаж, халдвар тархалтыг таслан зогсоох боломж бидэнд байна.

Иймд тус яамнаас эрүүл мэндийн болон бусад салбарт ажиллаж байгаа нийт эрүүл мэндийн ажилтнуудын дунд элэгний С вирүсын халдварын тархалтыг зогсоох зорилгоор “Эрүүл мэнд-Ээлтэй орчин” аяныг санаачлан үндэсний түвшинд зохион байгуулахаар төлөвлөж, удирдамжийг А/108 дугаар тушаалаар баталлаа. Энэхүү аяны хүрээнд эрүүл мэндийн ажилтнуудын дунд хепатитийн С вирүсын халдварыг илрүүлж, С вирүсын идэвхжлийг тодорхойлж, улмаар хепатитийн С вирүсын идэвхжилтэй хүнийг эмчилгээнд хамруулан эмчлэх, халдварыг таслан зогсоох шат дараалсан үйл ажиллагааг 4 дүгээр сарын эхний 7 хоногоос эхлэн 12 дугаар сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх юм.

Хепатитийн С вирүсын халдварыг илрүүлэх үзлэгт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь заалт, Эрүүл

¹ Монгол Улсын 40-өөс дээш насны хүн амын дундах хепатитийн В, С, D вирүсын халдварын тархалтыг тогтоох судалгаа. Судалгааны тайлан, Улаанбаатар хот, АШУУИС, 2009 он.

² Монгол Улсын эрүүл мэндийн ажилтнуудад цусаар дамжих зарим халдварын тархалтыг тогтоох нь. Судалгааны тайлан, Улаанбаатар хот, АШУУИС, 2017 он.

080001

мэндийн сайдын 2014 оны 186 дугаар тушаалд заасны дагуу одоо ажиллаж байгаа, нийгмийн даатгал төлдөг эрүүл мэндийн ажилтныг³ хамруулна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар даатгуулагчийн хепатитийн С вирусын идэвхжил тодорхойлох шинжилгээний зардлын төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Түүнчлэн энэ аяны ач холбогдлыг ойлгон дэмжиж, эм ханган нийлүүлэх байгуулагуудаас хепатитийн С вирусын эсрэг эмийг эрүүл мэндийн ажилтнуудад хямдруулсан үнээр нийлүүлэх боломжтойг мэдэгдэж эхлээд байна.

Иймд "Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аяныг даалгасан хугацаанд амжилттай зохион явуулахтай холбогдуулан та бүхнийг дараахь арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгож байна.

Нэг. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга, захирал нарт ДААЛГАХ нь:

1."Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аяныг өөрийн байгууллага, орон нутагт нөөц боломжийг дээд зэргээр ашиглан зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах,

2.Хепатитийн С вирусын халдварыг илрүүлэхэд ашиглах урвалж, оношлуур, идэвхжил тодорхойлох сорьц цуглуулахад шаардлагатай хэрэгслийн нөөц бүрдүүлэлтийг хангах,

3. "Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аянд өөрийн байгууллагын болон харьяа нутаг дэвсгэрт ажил, үйлчилгээ эрхэлж байгаа эрүүл мэндийн ажилтнуудыг аянд бүрэн хамруулж, оролцоог нь дэмжих,

5.Энэ аяны хүрээнд эрүүл мэндийн ажилтны ерөнхий болон халдварын эрсдлийн тухай мэдээллийн санг H-INFO програмд суурилан үүсгэх тул энэ ажилд өөрийн байгууллагын эрүүл мэндийн статистик мэдээллийн алба, хүний нөөцийн болон мэдээлэл технологийн мэргэжилтэнийг татан оролцуулах, хувь хүний мэдээллийн нууцлалыг хангах,

6.Хепатитийн С вирусын эсрэг эмчилгээний зааврын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эмч нартай ашиг сонирхлын зөрчилд холбогдохгүй анхааруулсан гэрээг үндсэн байгууллагатай хийх,

7."Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аяны хэрэгжилтийн явцын хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол мэдээлж, тайлагнах.

Хоёр. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт ДААЛГАХ нь:

1."Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аяныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах,
2.Хепатитийн С вирусын халдварыг илрүүлэхэд ашиглах урвалж, оношлуур, идэвхжил тодорхойлох сорьц цуглуулахад шаардлагатай хэрэгслийн нөөц бүрдүүлэлтийг хангах,

3."Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аянд өөрийн эмнэлэгт хөдөлмөрийн гэрээтэй ажилладаг, нийгмийн даатгал төлдөг эрүүл мэндийн ажилтнуудыг бүрэн хамруулж, оролцоог нь дэмжих,

³ Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.6-д заасны дагуу "эрүүл мэндийн ажилтан" гэж эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтныг оруулна.

**Гурав.Эрүүл мэндийн байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн холбоонд
ДААЛГАХ нь:**

1. "Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аяныг зохион байгуулах ажлын хэсэгт хамтрагчаар оролцох,

2. Эрүүл мэндийн яам болон харьяа байгууллагын веб хуудас, нийгмийн сүлжээ, бусад сурталчилгааны арга хэрэгслээр аяны үйл ажиллагааг идэвхтэй сурталчилах, уриалах замаар эрүүл мэндийн ажилтнуудын бүрэн оролцоог хангах,

**Дөрөв.Хепатитийн С вирусын эсрэг эмчилгээний зааврын сургалтад
хамрагдаж гэрчилгээ авсан эмч нарт ДААЛГАХ нь:**

1.Эмчийн тангарагаа дээдлэн аль нэг компаний орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд хамтрахгүй байх, ашиг сонирхлын зөрчилд холбогдохгүй байх,

Тав. Нийт эрүүл мэндийн ажилтан нарт ДААЛГАХ нь:

1.Иргэний болон эрүүл мэндийн ажилтны үүргээ ухамсарлан "Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аянд идэвх санаачлагатай оролцож, бусад ажилтныг уриалан оролцуулах.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ